

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ
БАЙГУУЛЛАГУУДЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН**

ОГНОО: 2021.04.25

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	САГ-2021/23/СТА-ТЕЗ	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Боловсрол, шинжлэх ухааны сайд
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Аудитын хоёрдугаар газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан	Ахлах аудитор: Б.Сэржмядаг

Хоёр. Байгууллага, нэгжийн тоо болон санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр/ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудит хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Итгэл үзүүлсэн	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Төсвийн ерөнхийлөн захирагч	1	-	-	-	-	1	-	-	-
2	Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	-	-	-	-	1	-	-	-
3	Засгийн газрын тусгай сан	2	-	-	-	-	1	1	-	-
4	Засгийн газрын тусгай сан	2	-	2	-	-	-	-	-	-
5	Төрийн өмчит үйлдвэрийн газар	13	-	1	-	-	12	-	-	-
6	Төсвийн шууд захирагч	80	-	19	3	-	46	11	1	-
	ДҮН	99	0	22	3	0	61	12	1	0

Гурав. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөг/

Дд	Харьяа байгууллагууд	Нийт	Дүгнэлтийн хэлбэр						Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Итгэл үзүүлсэн	Түүвэрт	Зөрчилгүй	Хязгаарлалт-тай	Сөрөг	дөт	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
99	НИЙТ ДҮН	99	3	22	61	12	1	0	344	21,544.4	40	4,819.8	112	10,148.1	192	6,576.5
	Төсвийн ерөнхийлөн захирагч															
1	Боловсрол, шинжлэх ухааны сайд	1			1				17	14,912.1	3	4,677.6	9	7,417.9	5	2,816.6
1	ДҮН	1				1			17	14,912.1	3	4,677.6	9	7,417.9	5	2,816.6
	Төсвийн төвлөрүүлэн захирагч															
1	Шинжлэх ухааны академи	1			1				5	11.4	1	10.5	1	-	3	0.9
1	ДҮН	1			1	0	0	0	5	11.4	1	10.5	1	-	3	0.9

	Засгийн газрын тусгай сан															
1	Шинжлэх ухаан технологийн сан	1				1			8	128.5			2	-	6	128.5
2	Боловсролын зээлийн сан	1			1				3	157.9			1	-	2	157.9
2	ДҮН	2			1	1	0	0	11	286.4	-	-	3	-	8	286.4
	Төсөл хөтөлбөр															
1	Суралцахуйг дэмжих мэргэжлийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх төсөл	1		1												
2	Палеонтологи, археологийн музейн шинэчлэл төсөл	1		1												
2	ДҮН	2	0	2	0	0	0	0								
	Төрийн өмчит үйлдвэрийн газар															
1	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль	1			1				6	271.2			3	82.8	3	188.4
2	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургууль	1			1				5	245.8			1	-	4	245.8
3	Монгол Улсын Боловсролын Их Сургууль	1			1				6	0.2	1	0.2	3	-	2	-
4	Монгол Улсын Их сургууль	1			1				7	201.8			3	40.4	4	161.4
5	Соёл Урлагийн Их Сургууль	1			1				4	47.7			3	44.7	1	3.0
6	Улаанбаатар Их Сургууль	1			1				4	33.9	1	2.8	1	8.7	2	22.4
7	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль	1			1				5	458.6			3	422.1	2	36.5
8	Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургууль	1			1				5	219.8			3	131.2	2	88.6
9	Ховд Их Сургууль	1			1				2	41.7				-	2	41.7
10	Дорнод Их сургууль	1			1				7	619.3	2	1.7	2	30.1	3	587.5
11	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл	1			1				5	70.0			2	-	3	70.0
12	Хөдөө аж ахуйн техникийн шинжлэх ухаан, технологи үйлдвэрлэлийн нэгдэл	1		1					0	-					-	-
12	ДҮН	12		1	11	0	0	0	56	2,210.0	4	4.7	24	760.0	28	1,445.3
	Төсвийн шууд захирагч															
1	Боловсрол, шинжлэх ухааны яам	1			1				4	85.9	1	3.6	3	82.3		
2	Хөтөлбөр арга хэмжээ	1		1					0	-						
3	Хөрөнгө оруулалт /Боловсрол/	1		1					0	-						
4	Хөрөнгө оруулалт /Шинжлэх ухаан/	1		1					0	-						
5	Барьцаа хөрөнгө	1		1					0	-						
6	Техник хяналт	1		1					0	-						
7	Тусгай зориулалтын шилжүүлэг	1		1					0	-						
8	Сурах бичиг түрээсийн тогтолцоо-эргэлтийн сан	1		1					0	-						
9	Багшийн хөгжлийн институт	1				1			8	43.4			3	25.0	5	18.4
10	Боловсролын хүрээлэн	1			1				6	44.8	1	0.2	1	37.0	4	7.6
11	Боловсролын үнэлгээний төв	1			1				5	56.5	1	14.8	2	27.3	2	14.4
12	Боловсролын мэдээллийн технологийн төв УТУГ	1			1				0	-						
13	Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа	1		1					0	-						
14	Насан туршийн боловсролын үндэсний төв	1		1					0	-						
15	Шинжлэх ухааны паркийн захиргаа	1		1					0	-						
16	Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль	1			1				3	13.8					3	13.8
17	Монгол тэмүүлэл төрийн өмчит Кембрижийн сургууль	1				1			8	82.0			4	82.0	4	-
18	Шинэ эрин төрийн өмчит сургууль	1			1				4	29.0					4	29.0
19	Шинэ эхлэл төрийн өмчит сургууль	1			1				5	0.3			1	-	4	0.3
20	ЕБ-ын 116-р тусгай сургууль	1					1		9	462.0	1	0.4	4	34.2	4	427.4
21	ЕБ-ын 29-р тусгай сургууль	1				1			6	264.7			3	264.7	3	-
22	Монгол улсын консерватор	1			1				3	33.5					3	33.5
23	Завхан. Хөгжим бүжгийн дунд сургууль	1			1				3	21.0	1	3.5			2	17.5
24	Шинжлэх ухааны академи	1		1					0	-					-	-
25	Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн	1		1					0	-					-	-

26	Газарзүй, гео-экологийн хүрээлэн	1			1			6	27.6					6	27.6	
27	Одон орон, геофизикийн хүрээлэн	1			1			3	43.8			1	-	2	43.8	
28	Олон улсын харилцааны хүрээлэн	1			1			3	13.2			1	7.1	2	6.1	
29	Физик технологийн хүрээлэн	1				1		4	54.3			1	-	3	54.3	
30	Философийн хүрээлэн	1		1				0	-					-	-	
31	Хими, хими технологийн хүрээлэн	1			1			0	-					-	-	
32	Хэл зохиолын хүрээлэн	1			1			2	5.5					2	5.5	
33	Археологийн хүрээлэн	1		1				0	-					-	-	
34	Биологийн хүрээлэн	1				1		10	682.7	1	7.6	4	490.5	5	184.6	
35	Геологийн хүрээлэн	1		1				0	-					-	-	
36	Математик, тоон технологийн хүрээлэн	1			1			5	6.6			1	4.3	4	2.3	
37	Палеонтологийн хүрээлэн	1				1		8	39.9	4	14.8			4	25.1	
38	Түүх, угсаатны зүйн хүрээлэн	1		1				0	-					-	-	
39	Анагаах ухааны хүрээлэн	1			1			3	10.2			1	-	2	10.2	
40	МАА-н эрдэм шинжилгээний хүрээлэн	1				1		8	141.1	1	1.5	3	45.1	4	94.5	
41	Мал эмнэлгийн хүрээлэн	1		1				0	-					-	-	
42	Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн	1			1			1	19.4					1	19.4	
43	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн	1			1			5	96.1					5	96.1	
44	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн	1			1			3	6.7			1	-	2	6.7	
45	Ургамал, газар тариалангийн хүрээлэн	1			1			12	74.5	3	22.9	1	1.6	8	50.0	
46	Уул уурхайн хүрээлэн	1				1		6	74.3	1	1.3	2	54.6	3	18.4	
47	Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн	1		1				0	-					-	-	
48	Цөмийн физикийн судалгааны төв	1				1		6	83.2	2	9.0	1	-	3	74.2	
49	Шинжлэх ухаан, технологийн сан	1		1				0	-					-	-	
50	Дулаан техник үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн	1			1			8	193.9	3	4.2	1	31.2	4	158.5	
51	Ар. Боловсролын газар	1			1			3	4.4					3	4.4	
52	Бу. Боловсролын газар	1	1					0	-							
53	Бх. Боловсролын газар	1			1			3	15.1			1	13.1	2	2.0	
54	Бө. Боловсролын газар	1	1					0	-					-	-	
55	Го. Боловсролын газар	1			1			5	1.1	3	1.1	2	-		-	
56	Гс. Боловсролын газар	1			1			8	37.0	4	35.4	2	-	2	1.6	
57	Да. Боловсролын газар	1			1			3	63.3	1	3.2			2	60.1	
58	Дундговь. Боловсролын газар	1			1			9	8.1			9	8.1		-	
59	Дорнод. Боловсролын газар	1			1			4	1.9			4	1.9		-	
60	Дорноговь Боловсролын газар	1			1			1	14.3					1	14.3	
61	За. Боловсролын газар	1			1			0	-		-			-	-	
62	Сү. Боловсролын газар	1	1					0	-							
63	Сэ. Боловсролын газар	1			1			2	0.8			1	0.8	1	-	
64	Ор. Бө. Боловсролын газар	1			1			3	9.3			1	1.3	2	8.0	
65	Ув. Боловсролын газар	1			1			1	1.5	1	1.5					
66	Өв. Боловсролын газар	1				1		2	441.0			2	441.0			
67	Өм. Боловсролын газар	1			1			5	215.8			5	215.8			
68	Хо. Боловсролын газар	1			1			4	164.0	1	0.1	1	86.7	2	77.2	
69	Хэ. Боловсролын газар	1			1			6	70.6	1	1.3	3	3.8	2	65.5	
70	Хө. Боловсролын газар	1			1			4	11.8	1	0.6			3	11.2	
71	Тө. Боловсролын газар	1			1			2	27.6					2	27.6	
72	Нийслэлийн боловсролын газар	1			1			5	196.4			1	4.6	4	191.8	
73	Бх. Боловсролын хэлтэс	1			1			4	80.6					4	80.6	
74	Чд. Боловсролын хэлтэс	1			1			4	6.2			2	6.2	2	-	
75	Бг. Боловсролын хэлтэс	1			1			1	0.7					1	0.7	
76	Бз. Боловсролын хэлтэс	1			1			2	-					2	-	
77	Б.нуур. Боловсролын хэлтэс	1			1			4	1.9					4	1.9	
78	Сх. Боловсролын хэлтэс	1			1			2	3.0					2	3.0	
79	Ху. Боловсролын хэлтэс	1			1			3	5.8					3	5.8	
80	Сб. Боловсролын хэлтэс	1			1			4	3.1					4	3.1	
81	На. Боловсролын хэлтэс	1				1		4	29.3			2	-	2	29.3	
81	ДҮН	81	3	19	47	11	1	0	255	4,124.5	32	127.0	75	1,970.2	148	2,027.3

3.2 . Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ач холбогдлоор нь эрэмбэлж танилцуулбал:

Алдаа, зөрчилтэй асуудал 1

Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжих, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлгийн барилгын төслийн санхүүжилтэд 2018 онд улсын төсвөөс Монголын талын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн зарцуулаагүй үлдэгдэл 1,925.6 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн харилцах дансанд байршуулсан.

Шийдвэрлэсэн нь: Завсрын аудитаар төлбөрийн акт тогтоосон.

Алдаа, зөрчилтэй асуудал 2

Ашиглалтад 2016-2018 онд орсон барилга байгууламжийн ажлын 37 аж ахуйн нэгж байгууллагад олгох 179.8 сая төгрөгийн барьцаа чөлөөлөх хугацаа дууссан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-т "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

Алдаа, зөрчилтэй асуудал 3

Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолыг үндэслэн 2019 оны эцэст барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан 2,572.2 сая төгрөгийн хэрэгжээгүй 20 хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилт барьцаа хөрөнгийн дансанд байршиж байна. Тус үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх албан бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн боловч шийдэгдээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-т "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл", Засгийн газрын 2019 оны "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар авах зарим арга хэмжээний тухай" 430 дугаар тогтоолын 1.2-т "банкны баталгааг үндэслэн олгосон санхүүжилт болон барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан 2020 оны 7 дугаар сарын 30-ны дотор Сангийн яамны зөвшөөрлөөр чөлөөлөх" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

Алдаа, зөрчилтэй асуудал 4

Барьцаа хөрөнгийн дансанд Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолыг үндэслэн байршуулсан хэрэгжээгүй 12 хөрөнгө оруулалтын ажлын 2,902.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй, Тус тогтоолын дагуу 4 хөрөнгө оруулалтын ажлын 2,320.2 сая төгрөгийг Чингис Хаан банкны баталгаагаар үндэслэн олгосон боловч, хөрөнгө оруулалтын ажил хийгдээгүй баталгааг гаргаж авах боломжгүй болсон, 2020 оны 253 дугаар тогтоолыг үндэслэн хэрэгжээгүй 4 хөрөнгө оруулалтын ажлын 1,162.3 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулан төсвийн гүйцэтгэлийн тайланд гүйцэтгэлээр тайлагнасан байна. Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.8-д "хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах"; Засгийн газрын 2019 оны "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар авах зарим арга хэмжээний тухай" 430 дугаар тогтоолын 1.2-т "банкны баталгааг үндэслэн олгосон санхүүжилт болон барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан гүйцэтгэлд хяналт

тавьж, баталгаажуулан 2020 оны 7 дугаар сарын 30-ны дотор СЯ-ны зөвшөөрлөөр чөлөөлөх” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Барьцаа хөрөнгийн дансанд байршиж байгаа хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэлээр санхүүжүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх

Алдаа, зөрчилтэй асуудал 5

Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлангийн бусад эргэлтийн хөрөнгө дансанд 2015-2019 онуудад үүссэн, ашиглалтад орсон боловч ашиглагч байгууллагад шилжүүлээгүй, улсын төсвийн санхүүжилт зогссон, гүйцэтгэгч байгууллага гэрээний үүргээ биелүүлээгүй, шүүхийн маргаантай гэх мэт 137,869.5 сая төгрөгийн 107 дуусаагүй хөрөнгө оруулалтын ажлын үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.8-д “хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах”; Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 8.1-д “Сангийн яам, Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 2.2.1-д заасан журмыг баримтлан төсвийн төсөлд тусгах төслийг сонгох болон төслийн санхүүжилтийг шийдвэрлэхдээ дараах эрэмбийг баримтална”, 8.1.1-д “шилжих буюу хэрэгжүүлж буй төсөл”, 15.5-т “....төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна”, 16.5-д “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл, өмчлөлийн асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасны дагуу шийдвэрлэнэ” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Улсын комиссын акт гарч ашиглалтад орсон, барилга байгууламжийн хөрөнгийн бүртгэл, өмчлөлийн асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасны дагуу шийдвэрлүүлэх; Улсын төсвийн санхүүжилт зогссон, гүйцэтгэгч байгууллага гэрээний үүргээ биелүүлээгүй, шүүхийн маргаантай шалтгааны улмаас хэрэгжихгүй байгаа хөрөнгө оруулалтын ажлуудын дэлгэрэнгүй судалгаа гаргаж, асуудлыг холбогдох байгууллага, албан тушаалтнаар шийдвэрлүүлэх;

Хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, тайлагналтай холбоотойгоор яамны газар, хэлтэс, албан тушаалтнуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, нэгдсэн мэдээ, файлын сан үүсгэж аудитын хугацаанд шаардлагатай тоо, мэдээгээр хангаж байх,

Алдаа, зөрчилтэй асуудал 6

Хөтөлбөр арга хэмжээний зардлаас буцалтгүй тусламж, шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн олговор, яамны гэрээт ажилтнуудын цалин, ахмадын арга хэмжээ, гадаад томилолтын зардалд нийт 200.2 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах арга хэмжээний тухай” 114 дүгээр тогтоолын 3.4-т “Төсвийн урсгал зардлаас дараах зардлыг санхүүжүүлэхийг хориглоно”, Сангийн сайдын 2014 оны Төсвийн эдийн засгийн ангилал батлах тухай 5, 2015 оны 55 дугаар тушаалаар баталсан журмын 6 дугаар хавсралт “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-ыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Хөтөлбөр арга хэмжээний зардлаас зориулалт бус зарцуулалт гаргахгүй байх, холбогдох хууль, журмыг мөрдөн ажиллах, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Алдаа, зөрчилтэй асуудал 7

Төрийн өмчит их сургуулиуд нь Улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэсэн статустай, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд төрийн өмчит үйлдвэрийн газар ангилалд нэгтгэгдэж, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тоо мэдээлэлд төрийн өмчит үйлдвэрийн газрын ангилалд ангилагдаж байгаа боловч санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Төсөвт байгууллагад мөрдөх санхүүгийн тайлангийн маягтаар тайлагнаж байна. Санхүүгийн тайлагналаа төсөвт байгууллагын батлагдсан маягтаар гаргаж байгаа бол Төрийн өмчит их сургуулиуд нь өөрийн орлогыг төсөвт тусган батлуулж, орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулахаар байна. Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, 4.1.3-т “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, Энэ хуулийн 4.1.3-т заасан стандартыг Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө”, Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34-т “төсвийн байгууллага” гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг”; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Төрийн өмчит их сургуулиудын төсөв, санхүүгийн тайлагнал, байгууллагын өмчийн хэлбэрийг хууль, журамтай нийцүүлэн тодорхойлох

Алдаа, зөрчилтэй асуудал 8

ХАА-н техникийн ШУТУ-ийн нэгдэл ТӨҮГ нь 2019-2020 онд үйл ажиллагаа явуулаагүй, эрх үүрэг тодорхойгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 19.1-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг /цаашид “захирал” гэх/ томилохдоо гэрээ байгуулна”, 19.1.2-т “Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин”, 20 дугаар зүйлийн 20.3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Үйл ажиллагаа явуулдаггүй ХАА-н техникийн ШУТУ-ийн нэгдэл ТӨҮГ-ыг хууль, журамтай нийцүүлэн шийдвэрлэх

Алдаа, зөрчилтэй асуудал 9

Дотоодын их дээд сургуульд хөнгөлөлттэй зээлээр 1995-2003 онд магистрын хөтөлбөрт суралцсан 95 төгсөгчийн 45.0 сая, 2004-2007 онд бакалаврын хөтөлбөрт суралцсан 3,128 төгсөгчийн 3,530.5 сая нийт 3,575.5 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй, Мөн 2008-2020 онд хөнгөлөлттэй зээлээр бакалавр, магистрын хөтөлбөрт суралцсан 11,267 төгсөгчийн 13,168.6 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй, зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна. Энэ нь Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь заалт, Засгийн газрын 2020 оны “Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай” 70 дугаар тогтоолын 3.4-т “Сургалтын төлбөрийн зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох асуудлыг Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8.8-д заасны дагуу Улсын Их Хурлаас баталсан журмын дагуу зохицуулна” гэсэн заалтууд тус тус хэрэгжихгүй байна;

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Зээлийн эргэн төлөх журамгүйгээс олон жил хуримтлагдсан 16,744.1 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн авлагыг шийдвэрлэх хууль эрхзүйн орчныг тодорхой болгох

Алдаа, зөрчилтэй асуудал 10

Гадаад орны дээд боловсролын байгууллагын бакалавр магистр, докторын хөтөлбөрт суралцаж байгаа суралцагчдад олгох сургалтын төлбөр, амьжиргааны зардлын зээлийн хэмжээг тогтоогоогүй, өмнөх оны завсрын аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журмын 1.5-д “Тухайн жилд дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутны тоог Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн оны 3 дугаар сард багтаан батална”, Дээд боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай 2020 оны 70 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Гадаад улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн зээл олгох журмын 2.1-д “Сургалтын төлбөрийн зээлийн хэмжээг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн, тухайн улсын амьжиргааны түвшинтэй харьцуулсны үндсэн дээр Засгийн газар жил бүр ялгавартайгаар тогтооно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутны тоо болон гадаад орны дээд боловсролын байгууллагын бакалавр магистр, докторын хөтөлбөрт суралцаж байгаа суралцагчдад олгох сургалтын төлбөр, амьжиргааны зардлын зээлийн хэмжээг журамд заасан хугацаанд жил бүр шинэчлэн тогтоож байх

Алдаа, зөрчилтэй асуудал 11

Тухайн жилд дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутны тоог БШУС-ын 2020 оны А/263 тоот тушаалаар 2020-2021 оны хичээлийн жилээс Дэлхийн шилдэг их сургуульд суралцах оюутны тоог 40 хүртэл баталсан байхад сайдын А/155 тушаалаар хяналтын тооноос илүү, сонгон шалгаруулалтгүй 19 суралцагчид 832.5 сая төгрөг олгож өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журмын 1.5-д “Тухайн жилд дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутны тоог Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн оны 3 дугаар сард багтаан батална” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Тухайн онд баталсан хяналтын тооноос илүү, сонгон шалгаруулалтад оролцоогүй суралцагчид хууль, журам зөрчиж сургалтын төлбөрийн санхүүжилт олгохгүй байх

Алдаа, зөрчилтэй асуудал 12

Шинжлэх ухаан, технологийн сангаас төслийн санхүүжилт авсан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, шинжлэх ухааны байгууллага, харьяа хүрээлэн, их сургуулиудын хэрэгжүүлсэн 12,640.5 сая төгрөгийн 211 төслийн хугацаа 2016-2019 онд дууссан боловч төслийн үр дүнг үнэлээгүй, гүйцэтгэгч нь захиалагч болон санхүүжүүлэгчид төслийн болон санхүүгийн тайланг хүлээлгэж өгөөгүй байна. Энэ нь Засгийн газрын 2014 оны 301 дүгээр тогтоолоор баталсан “Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам”-ын 7.3-т “Төслийн гүйцэтгэлийн явц захиалагч, санхүүжүүлэгчээс үл хамаарах шалтгаанаар удаашрах, үр дүн нь гэрээнд заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд захиалагч, санхүүжүүлэгч нь хугацаанаас өмнө гэрээг цуцлах, санхүүжүүлсэн хөрөнгийг гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх талаар шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад санал тавьж шийдвэрлүүлнэ”, мөн журмын 8.4.1-д “захиалсан үр дүн, санхүүжилтийн талаар зохих журмын дагуу бичсэн төслийн тайланг захиалагч, санхүүжүүлэгчид тогтоосон хугацаанд нь хүлээлгэн өгөх”, 8.4.2-т “төслийн хүрээнд бий болсон шинжлэх ухааны шинэ мэдлэг (энэ журмын 8.2-т тусгагдсан баримтаар баталгаажсан)-ийн талаар улсын стандартын дагуу бичсэн эрдэм шинжилгээний ажлын тайланг итгэмжлэн хадгалагчид төсөл дууссанаас хойш 3 сарын дотор цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүлээлгэн өгөх” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Төслийн гүйцэтгэлийн явц захиалагч, санхүүжүүлэгчээс үл хамаарах шалтгаанаар удааширсан, үр дүн нь гэрээнд заасан шаардлагыг хангаагүй төслийн гэрээг цуцлах, санхүүжүүлсэн хөрөнгийг гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх асуудлыг шийдвэрлэх; Төслийн захиалагч, санхүүжүүлэгч нар гүйцэтгэгчээс төслийн үр дүнг үнэлж, төслийн болон санхүүгийн тайланг хүлээн авч, гэрээний хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих

Алдаа, зөрчилтэй асуудал 13

ТЕЗ-ийн төсвийн төлөвлөлт тайлагналтай холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- ✚ Тусгай зориулалтын шилжүүлэг, хөрөнгө оруулалтын эрх шилжүүлсэн гүйлгээ нийт төсвийн гүйцэтгэлийн 76.0 хувь буюу 1,320,868.4 сая төгрөг байна;
- ✚ Төсвийн байгууллагын өөрийнх нь үндсэн үйл ажиллагаа, зардалтай холбоотой зарим төсвийг ТТЗ болон ХАХ-ний төсөв баталдаг;
- ✚ Төсвийн орлого, зарцуулалттай хамааралгүй сурах бичиг түрээсийн эргэлтийн сангийн орлогыг үндсэн үйл ажиллагааны орлогод баталсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1- “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.6.3-т “төсвийн захирагч нь өөрийн эрх, үүргээ доод шатны төсвийн захирагчид шилжүүлж болох боловч энэ нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй байх”, 14.2.11-д “төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Доод шатны төсвийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зардлыг тухайн байгууллагын төсөвт төсөвлөдөг байх, төсвийг үндэслэлтэй, бодитой төсөвлөж тайлагнах зөвлөмж өглөө

Алдаа, зөрчилтэй асуудал 14

Сурах бичиг эргэлтийн санд ЕБС-иуд номын түрээсийн орлогоос төвлөрүүлсэн 201.9 сая төгрөгийг авлагаар бүртгээгүй, түрээслүүлэхээр олгосон 7,408.5 сая төгрөгийн дансны үнэтэй сурах бичгийг журмын дагуу бүртгэл тайланд тусгасан эсэхэд журмын дагуу хяналт тавьж тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, Улсын төсвийн санхүүжилтээр үнэ төлбөргүй олгосон 3,144.4 сая төгрөгийн 1,436.8 мянган ширхэг сурах бичгийг БСУГ-аар дамжуулан ЕБС-уудад шилжүүлсэн боловч номыг хөрөнгийн дансанд бүртгэсэн эсэхэд тооцоо нийлж баталгаажуулан хяналт тавиагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, БШУС-ын 2019 оны Журам батлах тухай А/302 дугаар тушаалын 2.3.1-д “сурах бичгийг сургуулийн захирлын тушаалаар томилогдсон ажлын хэсэг хүлээн авч, акт үйлдэн эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэнэ” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сурах бичгийн түгээлт, бүртгэл тайлагнал, түрээсийн төлбөрт бүртгэлээр хяналт тавьж ажиллах, үр дүнг санхүүгийн тайланд тусгах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө

Алдаа, зөрчилтэй асуудал 15

ТЕЗ-ийн худалдан авалтаас 306 ААН-ийн 74,985.8 сая төгрөг цахим төлбөрийн баримтаар нотлогдохгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний

төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн баримтгүй ажил гүйлгээ хийхгүй байх, харилцагч байгууллагаас бүрэн гаргуулан авахад хяналт тавьж ажиллаж, цахим төлбөрийн баримтыг нөхөн авах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Алдаа, зөрчилтэй асуудал 16

Харьяа төсвийн байгууллагууд тайлант онд урсгал төсвөөс нийт 1,819.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байгаа нь Засгийн газрын 2020 оны Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах арга хэмжээний тухай 114 дүгээр тогтоолын 3.4-т “Төсвийн урсгал зардлаас дараах зардлыг санхүүжүүлэхийг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны Төсвийн эдийн засгийн ангилал батлах тухай 5 дугаар тушаалаар баталсан журмын 6 дугаар хавсралт Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах зааврыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагууд урсгал зардлаас материаллаг дүнтэй хөрөнгө бэлтгэхгүй байх, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө

Алдаа, зөрчилтэй асуудал 17

Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 99 тайлан нэгтгэснээс 96 тайлан аудитад хамрагдаж, Зөрчилгүй 60, Хязгаарлалттай 12, Сөрөг 1, түүвэрт хамрагдсан 23, итгэл үзүүлсэн 3 тайлан байна. Аудитаар нийт 290,739.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 103,594.5 сая төгрөгийн алдааг залруулж, харьяа байгууллагад илэрсэн 6,842.4 сая төгрөгийн 6 зөрчлийг аудитын тайланд тусгаж, 2,814.4 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 174,671.5 сая төгрөгийн 6 албан шаардлага хүргүүлж, 2,816.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудад өгсөн зөвлөмж, албан шаардлага, актын биелэлтийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг үнэлэх, зөрчлийг давтан гаргуулахгүй байхад анхаарч ажиллах зөвлөмж өглөө



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ГИШҮҮН, БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД Л.ЭНХ-АМГАЛАН
ТАНАА

2021.04.26 № 1330

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

A handwritten signature in black ink, appearing to read 'D. ZANDANBAT', is written over a faint, rectangular red stamp. The signature is stylized and cursive.

Д.ЗАНДАНБАТ